

- 5.7. Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт Холбооны эрх барих байгууллага нь Удирдах Зөвлөл байна.
- 5.8. Удирдах Зөвлөл нь 11 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг бүх гишүүдийн хурлаас дөрвөн жилийн хугацаатай сонгоно.
- 5.9. Энэхүү дүрмийн 5.8.-д заасан Удирдах зөвлөлийн 11 гишүүний бүрэлдэхүүнд дараах төрийн байгууллагуудаас тус бүр нэг гишүүн, нийт 4 гишүүн тухайн байгууллагыг төлөөлж байх ба үлдсэн 7 гишүүнийг Бүх гишүүдийн хурлаас сонгоно. Үүнд:
- 5.9.1. Эрүүл мэнд, спортын яам/Спорт хариуцсан төрийн яам/;
- 5.9.2. Монголын үндэсний олимпын хороо;
- 5.9.3. Нийслэлийн биеийн тамир, спортын газар;
- 5.9.4. Батлан хамгаалах салбарын аль нэг байгууллага;
- 5.10. Удирдах зөвлөлийн гишүүн нь нийгэмд эзэлсэн тодорхой байрь суурьтай, удирдан зохион байгуулах дадлага туршлагатай, зохих гадаад хэлний мэдлэгтэй, уулынспортыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, ял шийтгэлгүй Монгол улсын иргэн байна.
- 5.11. Удирдах зөвлөлийн гишүүнд уулын спортыг олон нийтэд буруу сурталчилсан, өмнөх Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хариуцсан ажлаа хангалтгүй гүйцэтгэж байсан, төрийн байгууллага болон элчин сайдын яамдуудад Холбооны нэрийг барьж ёс бус хандсан, байгууллага Холбооны нэр хүндийг унагасан, гэмт хэрэгт холбогдсон нь Шүүхээр Олон улсад Холбооны нэр хүндийг унагасан, төслийн холбогдсон нь Шүүхээр нотлогдсон, хуурамч бичиг баримт үйлдэж Холбоог төлоолохийг оролдсон зэрэг Холбооны нэр хүндэд сэргөөр нөлөөлөхүйц үйлдэд гаргаж байсан, байгаа ёс зүйн доголдолтой этгээдийг нэр дэвшүүлэх, сонгохыг хориглоно.
- 5.12. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 5.12.1. Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 5.12.2. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын албаны дотоод журам, Мэргэжлийн зөвлөл, Ёс зүйн зөвлөл болон тэмцээн уралдаан зохион байгуулах журам, шагнаж урамшуулах журам, тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдийг аттестатчлалын журам, ёс зүйн дүрэм болон холбооны үйл ажиллагаанд баримтлах бусад дүрэм, журам, заавар батлах;
- 5.12.3. Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтэн, уулын спортыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан байгууллага, хувь хүнийг холбогдо спортын байгууллагын болон төрийн шагналд нэр дэвшүүлж, тодорхойлох;
- 5.12.4. Холбооны тухайн жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
- 5.12.5. Зохих болзол, шалгуурыг хангасан иргэн, хуулын этгээд, байгууллагыг Холбооны гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлээс хасах;
- 5.12.6. Холбоонд элсэх гишүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гишүүний багамжийн хэмжээг тогтоох;
- 5.12.7. Холбооны ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, төсвийг батлах;
- 5.12.8. Холбооны хөрөнгийг захиран зарцуулах талаар Ерөнхий нарийн бичгийн даргын эрх хэмжээг тогтоох;
- 5.12.9. Дэд ерөнхийлөгчид болон Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгчтэй зөвшилцэж сонгох, түүний тайланг жил бүр хэлэлцэх;